

Ausgewählte Anteilnahme aus der Mongolei und der Inneren Mongolei, China

“Монгол судлалын нэрт эрдэмтэн, Герман Улсын Монгол судлалын өмөг түшиг, тулгуур нь болж байсан, монголчууд бидний анд нөхөр хүндэт профессор Ута Шене гуай таалал төгссөнд түүний гэр бүлийнхэнд, шавь нар, хамтран зүтгэгч нарт нь гүн эмгэнэл илэрхийлж байна. Миний бие Ута Шене багшийн урилгаар анх удаа 2004 онд Хумболдын их сургуульд зочин судлаачаар очиж, тэр эрхэм хүний сургаал, ухаарал хайрласан үгс, яриаг сонсож байсан билээ. Тэр үед Ута Шёне багшийн урсам бахдам сайхан монгол хэлээр ярихыг сонсоод бахдан бахархаж, гайхаж, бидний монголчууд үндэсний монгол хэлээрээ энэ багшийн хэмжээнд мэдэж байгаа билүү хэмээн өөрийн эрхгүй бодож байж билээ. Тэр үеэс хойш олон удаа Ута Шёне багштай уулзаж, Монголын талаарх сайхан сэтгэгдэл, үнэт дурсамж, яриаг сонсож байсан юм. Тэр бол оюутан цагаасаа Монголд ирж, Монгол судлалд бүхий л амьдралаа зориулсан нэрт эрдэмтэн, багш байсан бөгөөд бид түүний өгөөмөр сэтгэл, монголчуудыг гэсэн хайр, хүндлэлийг үргэлж дурсан санаж байх болно. Монгол судлалын арвин уламжлалтай Герман Улсын Хумболдын их сургуулийн Монгол судлалд хүнд гарз тохиосонд гүн эмгэнэл илэрхийлье.” Sc. D. BATSAIKHAN Ookhnoi, (Prof. Research Fellow, Mongolian Academy of Sciences, Institute of International Affairs)

“Тун харамсалтай явдал болжээ. Гүн эмгэнэл илэрхийлье.” Dr. Ч. Лодойравсал (Advisor to the President of Mongolia, Office of the President)

“Professor Uta Schöne nas nohcigsen chimeeg olood mashi emhenin gashuudaj baigaagaa tand ilerhiilye. Schöne bagshi saihaan hun baisan. 2005 онд би туунтэй Humboldt их сургуулийн Монгол хэлний tenghimд jolgon uuljaju mashi hogjeentei saihaan yarilchaj baisan. Ter uyed terber ganchaaraa nuser hund hicheel sudlaliin ajiliig daachilan hijj baisan bolovch ochuuhen ch halshiralgui jutgej yavan baisan. Tuunii saihaan sanaa setgel, mongol sudlald hairtai sethel nadad gun todhon suugdaltai bolj uldsen yum. Bagshi mani amurlingui noirsooroi!” Prof. Dr. Jakhadai Chimeddorji (Inner Mongolia University, Hohhot, Inner Mongolia, China)

„Тухайн үеийн Зүүн Герман дахь Монгол Судлалыг үүсгэн хөгжүүлж, монгол судлаачидыг бүхэл бүтэн үеийг сурган хүмүүжүүлсэн Хумбольдт их сургуулийн ахмад профессор, доктор Ута Шене багш таалал төгссөнд гүн эмгэнэлээ илэрхийлж байна. Монгол хэлний сургалт болон Монгол улс дахь боловсролын тогтолцооны талаар судалгаа хийж, Берлин дэх монгол судлалын гал голомтыг таслахгүйн тул түүний гаргасан үлэмж их хүчин зүдхэлийг бид бүхэн үүрд санан дурсах болно.“ Профессор Домийн Төмөртоогоо (Honorary President, International Association for Mongol Studies, Ulaanbaatar, Mongolia)

“Хумбольдтын их сургуулийн ахмад профессор, монгол судлаач Dr. sc. Ута Шёне нас нөгчсөнд Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын хамт олны өмнөөс түүний гэр бүл, найз нөхөд, хамтран зүтгэгчид, шавь

нар болон Хумбольдтын их сургуулийн Төв Азийн семинарын хамт олонд гүн эмгэнэл илэрхийлье.” Dr. Намжилчойжилын Алтантөгс (Vice Dean of Division of Humanity, School of Art and Science at National University of Mongolia, Ulaanbaatar)

“Архивын ерөнхий газрын нэрийн өмнөөс гүн эмгэнэл илэрхийлж байна.” С. Энхбаатар, (Director General of General Authority for Archives of Mongolia)

“Хумбольдтын их сургуулийн түшиг тулгуур болсон эрхэм профессорийн бие таалал төгссөн тухай мэдээг аваад манай сургууль, тэнхимийн багш суралцагчдын өмнөөс гүнээ эмгэнэл илэрхийлж байгааг хамт олон, гэр бүл, найз нөхдөд нь уламжилж өгнө үү. Ута Шёне багш МУИС-ийн Түүхийн тэнхим болон Хумбольдтын их сургуулийн хооронд хамтын ажиллагаа хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд манай багш оюутнуудтай эртнээс хамтран ажиллаж ирсэн хүн юм. Тэр бээр Монголд амьдарч байсан, монгол хүнд тун элгэмсэг, Монголын ард түмнийг чин сэтгэлээсээ хүндэтгэж явдаг хүн байсныг бид сайн мэднэ. Ута Шёне багш манай сургуулийн олон залууст монгол хэл, Монголын түүхийн хичээл зааж байсан ба хожим нь тэтгэвэртээ гарсны дараа ч Монгол судлалын чиглэлээр хичээл зааж байсан. Монголд түүний олон шавь академик байгууллага, их дээд сургуульд судлаач, дипломатч, орчуулагч, багш болон ажиллаж байна. Хумбольдтийн их сургуульд Монгол судлал өнөөг хүртэл оршиж байгаа нь эрхэм профессорын гавьяа билээ. Ум сайн амгалан болтугай!” Dr. Б. Чинзориг (Head of the Department of Historical Sciences, National University of Mongolia)

“Монгол судлаач, профессор Ута Шёне 4-р сарын 7-нд нас нөгчиж, монгол судлалын салбарт хүнд гарз тохиолоо. Профессор Ута Шёне нь 40 гаруй жилийн турш Берлиний Хумбольдтын Их Сургуульд багшилж, монгол хэл соёлыг заан сургах, монгол судлалыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм гавьяатай эрдэмтэн билээ. Ута Шёне 1960-1964 онд Берлин хотын Хумбольдтын нэрэмжит их сургуулийн Ази, Африк судлалын хүрээлэнгийн монгол-хятад судлалын анги, 1964-1966 онд Монгол Улсын Их Сургуулийн Хэл бичгийн факультетын монгол хэлний ангид суралцсан. 1975 онд “БНМАУ-ын боловсролын хөгжил” (1921-1971) сэдвээр дэд доктор, 1989 онд “1921-1960 онд БНМАУ-д явуулсан соёлын хувьсгалын гол зорилт, бэрхшээл, туршлага” сэдвээр түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Тэрээр түүх, нийгэм улс төр, эдийн засгийн чиглэлээр судалгаа хийж, Олон улсын монголч эрдэмтний гуравдугаар их хурлаас эхлэн удаа дараагийн хуралд эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлж, Олон улсын монгол судлалын холбооны үйл ажиллагаанд сэтгэл зүтгэлтэй оролцож байсан монгол судлаачдын хүндлэлийг хүлээсэн эрдэмтэн байлаа. ХБНГУ-ын Берлиний Хумбольдтын Их Сургуулийн монгол судлалын профессор Ута Шёне-гийн гэр бүл, хамт олон, шавь нарт нь гүн эмгэнэл илэрхийлье.” Олон улсын монгол судлалын холбоо (International Association for Mongol Studies)

Wir möchten Ihnen unseren aufrichtigen Dank für Ihre zahlreichen
Anteilnahmen aussprechen!